



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс зарим алдаа, зөрчлийг давтан гаргасан байна.



Сүхбаатар сум
2016 он

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын харьяа

Сэлэнгэ аймгийн

Аудитын газар

Тэргүүлэх аудитор

Ч.Энхтуяа

Аудитын менежер

Б.Батмөнх

Шинжээч

Ц.Уртнасан

Э.Эрдэнэзул

Ж.Цогт

2016 оны 12 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй

холбоотой

асуудлаар нэмж

тодруулах, асууж

лавлах зүйл байвал

70363036 дугаарын

утас, 70363040

дугаарын факсаар

харилцана уу.

ХАЯГ:Сэлэнгэ

аймгийн Сүхбаатар

сум, аймгийн ЗДТГ-

ын байрны

өргөтгөлд

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Хоёр. Үндсэн мэдээлэл

Гурав. Аудитын дүн

А. Орон нутгийн хурлын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх?

А.1 Төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон эсэх?

А.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?

Б. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх?

Б.1 Төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэх?

Б.2 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх?

Дөрөв. Илрүүлсэн зөрчил

Тав. Аудитын дүгнэлт

Зургаа. Зөвлөмж

Холбогдох байгууллагын санал

Саналд өгсөн тайлбар

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид
МУ	Монгол Улс
МТБ	Мэдээлэл технологийн баг
НА	Нийцлийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОӨУБЕГ	Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

1.Аудитын нэр: Орон нутгийн хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл

2. Аудитын код: УАГ-НАГ/2016/07-НА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын зорилт:

Сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт оршив.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэх?
- Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх?

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Цагдаагийн газар зэрэг байгууллагуудад улсын төсвөөс олгосон сонгуулийн зардлын хуваарилалт, гүйцэтгэлийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад материалуудыг хамрууллаа.

6. Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, АДБОУС 4000, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийн, асуулга лавлагаа, тодруулга аван, тайлан, судалгаа, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- УИХ-ын 2016 оны 27 дугаар тогтоол
- Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн акт, стандарт

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Батмөнх хэрэгжүүлэн, шинжээч Ц.Уртнасан, Э.Эрдэнэзул, Ж.Цогт нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Хоёр.Үндсэн мэдээлэл

Сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6¹ дахь заалтын дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 72 дугаар тогтоолоор сумын ИТХ-ын сонгуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий аймгийн сонгуулийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4² дэх заалтыг үндэслэн 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор сумдын сонгуулийн хороог 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр, сумдын сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 35.3³, 35.4⁴ дахь заалтын дагуу 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэсгийн хороодыг байгуулсан байна.

Аймгийн сонгуулийн хороонд нягтлан бодогч, нярвын хамт 9, сумдын салбар хороонд 101, хэсгийн хороонд 454 гишүүн, мэдээлэл технологийн даамал 90 зэрэг нийт 654 төрийн албан хаагчид ажилласан байна. */Дэлгэрэнгүйг хавсралт №1-д үзүүлэв/.*

Сонгуулийн тухай хуулийн 23.2⁵ дахь заалт болон хүн амын нягтаршил, газар зүйн байршлыг харгалзан салбар хороог 2-15 хэсэгтэй буюу нийт 68 хэсгийн хороог зохион байгуулжээ. Хамгийн бага нь Баянгол сумын 896-р хэсгийн хороо 179

¹ Сум, дүүргийн хурлын сонгуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах аймаг, нийслэлийн сонгуулийн хороог энэ хуулийн 16.2-т заасан хугацаанаас өмнө 80 хоногийн өмнө аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид энэ хуульд нийцүүлэн байгуулна.

² Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

³ Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал авах байрыг санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, ахлах зохион байгуулагчийг томилно.

⁴ Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал авах байрын бусад зохион байгуулагчийг санал авах өдрөөс долоогоос доошгүй хоногийн өмнө томилно.

⁵ Нэг хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 2500-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 3000-аас дээшгүй сонгогчтой байна.

сонгогчтой, хамгийн их нь Сүхбаатар сумын 887-р хэсгийн хороо 2313 сонгогчтой байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-т үзүүлэв./

Сумын ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотойгоор СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд 290,067.2 мянган төгрөгийн, ОӨУБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 39,054.5 мянган төгрөгийн, ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт 6,330.0 мянган төгрөгийн зэрэг нийт 335,451.7 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилж олгосон байна.

Гурав. Аудитын дүн

Бүлэг А. Орон нутгийн хурлын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулсан эсэх?

А.1 Төсвөөс олгох хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг бодитой тооцсон эсэх?

Зарим зардлыг бодит байдлаас өндрөөр тооцож төлөвлөсөн байна.

СЕХ-ны 2016 оны 09-р сарын 15-ны өдрийн 257 тоот албан бичгээр Сэлэнгэ аймгийн сонгуулийн хороонд 98,596.0 мянган төгрөгийн, 2016 оны 10-р сарын 10-ны өдрийн 621 тоот албан бичгээр 191,471.2 мянган төгрөгийн зэрэг нийт 290,067.2 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилж, бүрэн олгосон байна.

МУ-ын Сонгуулийн тухай хуулийн 38.1⁶ дахь заалтын дагуу СЕХ нь сонгуулийн зардлын төлөвлөлтийг хийж УИХ-аар батлуулсан бөгөөд холбогдох тооцооллын дагуу аймгийн сонгуулийн хороо, санал авах байрны төсвийг зардлын эдийн засгийн ангилалаар нь баталж ирүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос ирүүлсэн зөвлөмжийн дагуу зардлыг сумын сонгуулийн хороо, санал авах байранд хуваарилсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /мян.төгрөг/

д/д	Зардлын төрөл	Төлөвлөгөө			Нийт		Нийт үлдэгдэл
		Аймгийн сонгуулийн хороо	Сумын салбар хороо	Санал авах байр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Бичиг хэргийн зардал	1,350.0	2,625.0	5,440.0	9,415.0	9,397.5	17.5
2	Шуудан холбооны зардал	1,350.0	2,550.0	5,440.0	9,340.0	8,911.6	428.4
3	Унааны зардал	2,000.0	8,800.0	25,500.0	36,300.0	36,300.0	-

⁶ Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг хүн амын тоог сонгуулийн нутаг дэвсгэртэй харьцуулан гаргасан сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална.

4	Сурталчилгааны зардал	1,200.0	6,800.0	-	8,000.0	8,000.0	-
5	Санал авах байр бэлтгэх зардал	3,222.0	-	6,800.0	10,022.0	6,799.7	3,222.3
6	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	350.0	-	-	350.0	336.9	13.1
7	Үнэмлэх хэвлүүлэх зардал	1,700.0	-	-	1,700.0	1,680.0	20.0
8	Сургалтын зардал	14,668.0	-	-	14,668.0	14,325.1	342.9
9	Томилолтын зардал	2,890.0	2,108.0	-	4,998.0	3,664.8	1,333.2
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах зардал	600.0	-	-	600.0	592.0	8.0
11	Болзошгүй зардал	300.0	2,200.0	-	2,500.0	2,200.0	300.0
12	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	92.0	-	3,360.0	3,452.0	3,360.0	92.0
13	Сурталчилгааны материал тараах зардал	150.0	1,700.0	-	1,850.0	1,751.5	98.5
14	Хоолны зардал	630.0	6,590.0	22,700.0	29,920.0	29,920.0	-
15	Урамшуулал	2,419.2	23,270.4	88,473.6	114,163.2	114,163.2	-
16	МТБ, Даамлын урамшуулал, хоолны зардал	1,928.0	22,134.0	-	24,062.0	24,062.0	-
17	Бичиг хэрэг, ня-богийн урамшуулал, хоолны зардал	900.0	-	-	900.0	900.0	-
18	Саналын хуудас УБ хотоос авах, суманд хүргэх, ИСР машиныг УБ хотоос хүлээн авах, хүлээлгэн өгөх,	17,827.0	-	-	17,827.0	10,915.7	6,911.3
	Нийт зардлын дүн	53,576.2	78,777.4	157,713.6	290,067.2	277,280.0	12,787.2

Дээрх хүснэгт болон сонгуулийн зардлын гүйцэтгэлээс харахад аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-ноос өгсөн зөвлөмж, сонгогчийн болон хэсгийн тоо, газар нутгийн хэмжээ, сумдын сонгуулийн хороонд ажиллах гишүүдийн тоог харгалзан зардлын хуваарийг хийсэн хэдий ч зарим зардлуудыг хэтэрхий өндрөөр төлөвлөснөөс дараах хэмнэлт гарсан байна. Үүнд:

🚦 Аймгийн сонгуулийн хороонд олгосон 1 км-т ноогдох унааны зардлыг бодит байдлаас өндрөөр тооцсоноос саналын хуудас болон ИСР машиныг УБ хотоос авчрах, сумдад хүргэх, буцааж авч ирэх зардал 6,911.3 мянган төгрөгөөр

🚦 Сумын сонгуулийн хорооноос аймагт сонгуулийн дүн хүргэх 1 км-т ноогдох унааны зардлыг бодит байдлаас өндрөөр тооцсоноос шалтгаалж, уг зардалд 2,400.0 мянган төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 1,180.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,220.0 мянган төгрөгөөр

СЕХ-ноос санал авах байр бэлтгэх зардалд 68 хэсгийн хороо тус бүрт 200.0 мянган төгрөгөөр тооцож баталсныг аймгийн сонгуулийн хороо нь хэсгийн хороо тус бүрт 100.0 мянган төгрөгөөр тооцож олгосноос уг зардал 6,800.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Дээрхээс үзэхэд сонгуулийн зарим зардлыг орон нутгийн бодит үнэ, жишиг тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр төлөвлөсөн байгаа нь Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын 2-р хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 4.4⁷ дэх заалтыг зөрчсөн байна.

А.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, арвилан хэмнэлттэй зарцуулсан эсэх?

Аймаг, сумдын сонгуулийн хороод нь анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд сумын ИТХ-ын сонгуулийг зохион байгуулахад 290,067.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос гүйцэтгэлээр 277,280.0 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн хэмнэлт 12,787.2 мянган төгрөгийг 2016 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр СЕХ-ны 900022001 тоот дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Зарцуулалтыг зардлан ангиллаар хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт №2 /мян.төгрөг/

д/д	Зардлын төрөл	Нийт төлөвлөгөө	Гүйцэтгэл			Нийт Гүйцэтгэл
			Аймгийн сонгуулийн хороо	Сумын сонгуулийн хороо	Санал авах байр	
1	Бичиг хэргийн зардал	9,415.0	1,332.5	2,625.0	5,440.0	9,397.5
2	Шуудан холбооны зардал	9,340.0	921.6	2,550.0	5,440.0	8,911.6
3	Унааны зардал	36,300.0	2,000.0	8,800.0	25,500.0	36,300.0
4	Хууль тогтоомж сурталчлах зардал	8,000.0	1,200.0	6,800.0	-	8,000.0
5	Санал авах байр бэлтгэх зардал	10,022.0	-	-	6,799.7	6,799.7
6	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	350.0	336.9	-	-	336.9

⁷ Энэ аргачлалын 4.2.3-т заасан бараа, ажил, үйлчилгээний дундаж үнэ тарифыг Үндэсний статистикийн хорооноос гаргасан хэрэглээний сагсанд багтсан барааны үнэ болон эрх бүхий байгууллагаас үнэ тариф тогтоосон холбогдох эрх зүйн актыг тус тус үндэслэнэ.

7	Үнэмлэх хэвлүүлэх зардал	1,700.0	1,680.0	-	-	1,680.0
8	Сургалтын зардал	14,668.0	14,325.1	-	-	14,325.1
9	Томилолтын зардал	4,998.0	1,556.8	2,108.0	-	3,664.8
10	Мэдээлэл технологийн багийн мэдээ дамжуулах зардал	600.0	592.0	-	-	592.0
11	Болзошгүй зардал	2,500.0	-	2,200.0	-	2,200.0
12	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	3,452.0	-	-	3,360.0	3,360.0
13	Сурталчилгааны материал тараах зардал	1,850.0	51.5	1,700.0	-	1,751.5
14	Хоолны зардал	29,920.0	630.0	6,590.0	22,700.0	29,920.0
15	Урамшуулал	114,163.2	2,419.2	23,270.4	88,473.6	114,163.2
16	МТБ, Даамлын урамшуулал, хоолны зардал	24,062.0	1,928.0	22,134.0	-	24,062.0
17	Бичиг хэрэг, ня-богийн урамшуулал, хоолны зардал	900.0	900.0	-	-	900.0
18	Саналын хуудас УБ хотоос авах, суманд хүргэх, ИСР машиныг УБ хотоос хүлээн авах, хүлээлгэн өгөх,	17,827.0	10,915.7	-	-	10,915.7
	Нийт зардлын дүн	290,067.2	40,789.3	78,777.4	157,713.3	277,280.0

Аудитаар аймаг, сумдын сонгуулийн хороодын зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Дэд бүтцийн сайдын 2004 оны 19-р тушаалын 1-р хавсралтаар батлагдсан "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг мөрдөөгүйгээс дараах сумдын сонгуулийн хороод шатахууны зардлыг илүү тооцож олгосон байна. Үүнд:

 Сант сум 57.4 мянган төгрөгийн,
 Жавхлант сум 41.5 мянган төгрөгийн,
 Түшиг сум 293.2 мянган төгрөгийн зэрэг нийт 392.1 мянган төгрөгийн шатахууны зардлыг илүү тооцож олгосон байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.4 “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- ✚ Аймгийн сонгуулийн хороо СЕХ-нд санхүүгийн тайлан тушаах нягтлан бодогч, жолооч нарт 103.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг томилолтын хуудасгүйгээр олгосон,
- ✚ Баянгол, Цагааннуур сумдын сонгуулийн хороо нь сонгуулийн дүн тушаах ажлын унааны зардлын 130.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүйгээр олгосон,
- ✚ Орхон, Орхонтуул, Түшиг, Хушаат сумдын сонгуулийн хороо, санал авах байранд ажилласан гишүүд, мэдээллийн технологийн даамлуудын хоол, урамшууллын мөнгийг банкны түр дансанд шилжүүлсэн боловч жагсаалт үйлдэж, хүлээн авсан хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулалгүй 18,495.1 мянган төгрөгийг олгосон,
- ✚ Алтанбулаг, Орхон, Түшиг, Мандал сумд нь шуудан холбооны зардлын 655,0 мянган төгрөгийг хүлээн авсан хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулалгүйгээр олгосон,
- ✚ Орхон, Түшиг, Зүүнбүрэн сумдын төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй 1,430.0 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн,
- ✚ Алтанбулаг сумын сонгуулийн хорооны дарга Б.Саруултөгст 1 өдрийн томилолтын зардал 29.0 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна.

Аймгийн сонгуулийн хороо нь 2016 оны 09-р сарын 20-ны өдрийн 17 тоот албан бичгээр сумдын сонгуулийн хороонд сонгуулийн төсвийн зарцуулалтын тухай зөвлөмжийг хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✚ Шаамар, Сайхан сумдын сонгуулийн хороо нь утасны төлбөрийн хэмжээ тогтоосон шийдвэргүйгээр 550.0 мянган төгрөгийг олгосон байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгуулийн хэмнэгдсэн зардлаас байгууллагын НДШ-ийн зардлыг төлсөн байна.

ОӨУБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн 130012420 тоот дансаар дамжуулан 39,054.5 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилан, бүрэн олгосон байна. Санхүүжилтийн зарцуулалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3 /мян.төгрөг/				
№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх бичиг хэрэг, бусад	6,000.0	5,633.2	366.8
2	Итгэмжлэгдсэн ажилтны цалин, НДШ, унаа хоол	18,881.5	18,734.5	147.0

3	Итгэмжлэгдсэн ажилтны техник хэрэгсэл хүргэх зардал	3,213.0	3,213.0	-
4	Итгэмжлэгдсэн ажилтны сургалтын зардал	5,960.0	5,310.0	650.0
5	Дахин сонгуулийн зардал	5,000.0	5,000.0	-
Нийт		39,054.5	37,890.7	1,163.8

Сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах болон санал авах техник хэрэгслийг татан авах, тээвэрлэж хүргүүлэх болон түүнтэй холбогдсон албан хаагчийн сургалт зохион байгуулах болон унаа, хоол, томилолт, цалингийн зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- *Итгэмжлэгдсэн ажилтны цалингаас 1,565.3 мянган төгрөгийн НДШ-ийг суутган тооцоогүй байна.*
- Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журмын 3.3-т “Сонгуулийн санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор сонгуулийн зардлын үлдэгдлийг Сонгуулийн Ерөнхий Хорооны дансанд эргүүлэн төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчин сонгуулийн зардлаас хэмнэгдсэн 1,163.8 мянган төгрөгөөр аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн НДШ-ийн зардлыг төлж, зориулалт бусаар зарцуулсан байна.

Аймгийн Цагдаагийн газар нь олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

ЦЕГ-аас сонгуулийн саналын хуудас хүргүүлэх, хадгалах болон санал авах байрны хамгаалалтад ажиллах алба хаагчдын хоол, холбоо, шатахууны зардалд 6,330.0 мянган төгрөгийг аймгийн Цагдаагийн газрын 130012401 тоот нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан олгосон байна.

Хүснэгт №4 /мян.төгрөг/

№	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Хоолны мөнгө	4,110.0	4,110.0
2	Холбоо	420.0	420.0
3	Шатахуун	1,800.0	1,800.0
НИЙТ		6,330.0	6,330.0

Аймгийн Цагдаагийн газар нь олгосон санхүүжилтийг, зориулалтын дагуу зарцуулж, холбогдох анхан шатны баримт, материалыг бүрдүүлэн ажилласан байна.

Бүлэг Б. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх?

Б.1 Төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан эсэх?

Төсвийн гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.

Сэлэнгэ аймгийн сонгуулийн хороонд СЕХ-ны 2016 оны 09-р сарын 15-ны өдрийн 257 тоот албан бичгээр 98,596.0 мянган төгрөгийн, 2016 оны 10-р сарын 10-ны өдрийн 621 тоот албан бичгээр 191,471.2 мянган төгрөгийн зэрэг нийт 290,067.2 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилж, төсвийн хуваарийг батлан ирүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хороо 2016 оны 10-р сарын 26-ны өдрийн 40 тоот албан бичгээр Зүүнбүрэн сумын 906, Түшиг сумын 935, Шаамар сумын 946 дугаар хэсгүүдэд дахин санал хураалт явагдах болсонтой холбоотой унааны зардал, бичиг хэргийн зардал, эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал, сонгуулийн хороодод ажилласан хүмүүсийн хоолны зардал, ИСР машиныг УБ хотоос хүлээн авах, хүлээлгэн өгөхтэй холбоотой нийт 4,061.0 мянган төгрөгийн зардлыг санал авах байр бэлтгэх зардлаас зарцуулах хүсэлтээ СЕХ-нд хүргүүлсэн байна.

Үүний дагуу СЕХ-ноос 2016 оны 10-р сарын 28-ны өдрийн 287 тоот албан бичгээр аймгийн сонгуулийн хороонд шинэчлэн батлагдсан төсвийн хуваарийг дараах байдлаар батлан ирүүлсэн байна. Үүнд:

- Санал авах байр бэлтгэх зардлаас 3,578.0 мянган төгрөгийг бууруулан,
- Унааны зардалд 300.0 мянган төгрөгийг,
- Бичиг хэргийн зардалд 75.0 мянган төгрөгийг,
- Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардалд 120.0 мянган төгрөгийг,
- Сонгуулийн хороонд ажилласан хүмүүсийн хоолны зардалд 1,820.0 мянган төгрөгийг,
- УБ хотоос саналын хуудас авах, ИСР машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх зардалд 1,263.0 мянган төгрөгийг тус тус нэмэгдүүлсэн байна.

Аймгийн сонгуулийн хорооны төсвийн хуваарийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5 /мян.төгрөг/

□/□		Зардлын нэр	Анхны батлагдсан төсөв	Шинэчлэгдсэн батлагдсан төсөв
1		Бичиг хэргийн зардал	9,340.0	9,415.0
2		Шуудан холбооны зардал	9,340.0	9,340.0
3		Унааны зардал	36,000.0	36,300.0

4		Хууль тогтоомж сурталчлах зардал	8,000.0	8,000.0
5		Санал авах байр бэлтгэх зардал	13,600.0	10,022.0
6		Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал	350.0	350.0
7		Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх зардал	1,700.0	1,700.0
8		Сургалтын зардал	14,668.0	14,668.0
9	Томилолт	Саналын хуудас баталгаажуулах	639.5	639.5
		Саналын хуудас хэвлүүлэх	639.5	639.5
		Сумын сонгуулийн хорооноос аймагт сонгуулийн дүн хүргэх	3,328.0	3,328.0
		Аймгийн сонгуулийн хорооны нягтлан СЕХ-нд санхүүгийн тайлан хүлээлгэж өгөх	391.0	391.0
10		МТБ-ийн мэдээ дамжуулах зардал	600.0	600.0
11		Болзошгүй зардал	2,500.0	2,500.0
12		Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардал	3,332.0	3,452.0
13		Сурталчилгааны материал хүргэх зардал	1,850.0	1,850.0
14		Сонгуулийн байгууллагын ажилтан сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	143,163.2	144,983.2
15		Мэдээлэл технологийн багийн гишүүн, даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	24,062.0	24,062.0
16	Саналын хуудас авах	Саналын хуудас авах зардал	5,712.0	5,712.0
		ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх	10,852.0	12,115.0
		ДҮН	290,067.2	290,067.2

Аймгийн сонгуулийн хороо нь шинэчлэн баталсан төлөвлөгөөний дагуу төсвийг зарцуулан гүйцэтгэлийг бодитоор тайлагнасан байна.

Б.2 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй эсэх?

Аймгийн сонгуулийн хороо нь зарим сумдын сонгуулийн хорооны зардлын тайланг журмын дагуу акт үйлдэж хүлээн аваагүй байна.

СЕХ-ны 2016 оны 03-р сарын 02-ны өдрийн 04 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах

журам”-ын 3-р зүйлийн 3.4-т “... аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хорооны, төв комисс нь салбар комиссын сонгуулийн зардлын зарцуулалтад тус тус хяналт тавина” гэж заасан байдаг.

Дээрх заалтын дагуу аймгийн сонгуулийн хорооноос сумдын сонгуулийн хороо, санал авах байрнуудын ажил, төсвийн хуваарилалт, зарцуулалтыг шалган танилцах тухай ажлын удирдамж батлан сумдад ажилласан боловч илтгэх хуудас, ажлын тайлангаар баталгаажуулаагүй байна.

СЕХ-ны 2016 оны 03-р сарын 02-ны өдрийн 04 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 4.3-т “Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комиссын сонгуулийн зардлын тайлан дараах хэсгээс бүрдэнэ” гэж заасан боловч Баянгол, Сайхан, Цагааннуур сумдын сонгуулийн хороо нь зардлын тайлангийн товч танилцуулга, тодруулгыг ирүүлээгүй байна.

Сумдын сонгуулийн зардлын тайлангийн бүрдлийг харуулвал:

Хүснэгт №6

№	Сумдын нэр	Тайлан хүргүүлсэн албан бичиг	Тайлангийн товч танилцуулга, Тодруулга	Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлан	Санхүүгийн АШБ, хүлээлгэн өгсөн акт
1	Алтанбулаг	+	+	+	+
2	Ерөө	+	+	+	-
3	Зүүнбүрэн	+	+	+	-
4	Мандал	+	+	+	+
5	Орхон	+	+	+	-
6	Сант	+	+	+	+
7	Цагааннуур	+	-	+	-
8	Баянгол	+	-	+	+
9	Сайхан	+	-	+	-
10	Орхонтуул	+	+	+	-
11	Баруунбүрэн	+	+	+	+
12	Шаамар	+	+	+	+
13	Хүдэр	+	+	+	-
14	Сүхбаатар	+	+	+	+
15	Жавхлант	+	+	+	+
16	Түшиг	+	+	+	-
17	Хушаат	+	+	+	+

Мөн журмын 4.6-т “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн ИТХ-ын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө” гэж заасан боловч Ерөө, Зүүнбүрэн, Орхон,

Орхонтуул, Сайхан, Цагааннуур, Хүдэр, Түшиг сумдын сонгуулийн хорооноос ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг акт үйлдэн хүлээн аваагүй байна.

Дөрөв. Илрүүлсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитаар дараах зөрчлүүдэд албан шаардлага бичигдлээ.

Албан шаардлага:

Аймгийн сонгуулийн хороо:

1. Холбогдох норм, нормативыг мөрдөөгүйгээс 392.1 мянган төгрөгийн шатахууныг илүү тооцож зарцуулсан,
2. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 20,842.1 мянган төгрөгийн ажил, гүйлгээг бүртгэлд тусгасан зэрэг нийт **21,234.2 мянган** төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага,

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс:

1. Итгэмжлэгдсэн 78 ажилтны цалингаас НДШ-ийг суутган тооцоогүй 1,565.3 мянган төгрөг
2. Хэмнэгдсэн зардлыг байгууллагын НДШ-ийн зардалд шилжүүлсэн 1,163.8 мянган төгрөг зэрэг нийт **2,729.1 мянган** төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага.

Тав. Дүгнэлт

- ✓ Унааны болон санал авах байр бэлтгэх зардлыг бодитой тооцож, төлөвлөөгүй байна.
- ✓ Сонгуулийн хороод нь анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.
- ✓ Сонгуулийн зардлын гүйцэтгэлийг бодитой тайлагнасан байна.
- ✓ Унааны зардлыг илүү тооцон зарцуулсан байна.
- ✓ Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хорооны тайланг журмын дагуу хянаж хүлээн аваагүй байна.
- ✓ Улсын бүртгэлийн хэлтэс нь итгэмжлэгдсэн ажилтны цалингаас НДШ суутган тооцоогүй байна.
- ✓ Улсын бүртгэлийн хэлтэс нь хэмнэгдсэн зардлаас байгууллагын НДШ-ийн зардлыг төлсөн байна.

Зургаа. Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн сонгуулийн хорооны дарга Э.Оюунболд-д:

- ✓ Сумын болон хэсгийн хороодын сонгуулийн зардлыг бодитоор тооцож хуваарилах.
- ✓ Сумдын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу хянаж хүлээн авах.
- ✓ Анхан шатны баримтын бүрдлийг хангах, сонгуулийн хороодын зардлын гүйцэтгэлд хяналт тавих.

Сумдын сонгуулийн хорооны дарга нарт:

- ✓ Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах.
- ✓ Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг архивын нэгж үүсгэн журмын дагуу аймгийн сонгуулийн хороонд хүлээлгэн өгч байх.

Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Алтантуяа-д:

- ✓ Хуваарилагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн хэмнэлтийг СЕХ-ны дансанд татан төвлөрүүлэх.
- ✓ Алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ШИНЖЭЭЧ

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Ц.УРТНАСАН
Э.ЭРДЭНЭЗУЛ
Ж.ЦОГТ